



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Экспортыг дэмжих төсөл”-ийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 4,997,280.00 (дөрвөн сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуун наян) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Экспортыг дэмжих төсөл”-ийн нэгжийн зохицуулагч Б.Дөлгөөн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн захирал Б.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004635
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 03 дугаар сарын 6 ны өдрийн
 38 дугаар тогтоолын хавсралт

"ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ"-ИЙН НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
 ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Нэр, төрөл	Ашиглалтан д орсон огноо	Үндсэн хөрөнгийн анхны өртөг			Хуримтлагдсан элэгдэл /төгрөг//	Үлдэгдэл өртөг /төгрөг/
			Тоо хэмжээ /ширхэг /	Балансын нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт балансын үнэ /төгрөг/		
1	Сургалтын ширээ /шаргал /	2020.07.10	10	227,182.00	2,271,820.00	549,023.00	1,722,797.00
2	Сургалтын сандал / дугуйтай, цэнхэр /	2020.07.10	20	136,273.00	2,725,460.00	658,653.00	2,066,807.00
	Нийт дүн		30		4,997,280.00	1,207,676.00	3,789,604.00
					(дөрвөн сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуун ная)	(нэг сая хоёр зуун долоон мянга зургаан зуун далан зургаа)	(гурван сая долоон зуун наян есөн мянга зургаан зуун дөрөв)